



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2023 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн өмчөөс шилжүүлсэн 23,100,000.00 (хорин гурван сая нэг зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж биет бус хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Баярхүү, Говьсүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга З.Баяндугар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Газар эзэмших эрхийг нэр шилжүүлэн баталгаажуулах, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004941  
10-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны ... дугаар сарын ... өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ХЭСЭГЧЛЭН  
 ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГӨ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Газар эзэмших эрх	2011	Сүмбэр сум, 2 дугаар баг	м.кв	1540	15,000.00	23,100,000.00	-	23,100,000.00
<b>Нийт дүн</b>									
							(хорин гурван сая нэг зуун мянга)		(хорин гурван сая нэг зуун мянга)